



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 07 өдөр Дугаар 65

Хэрлэн сум

LXV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 65 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 20:30 цагт цахимаар 89,4 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улсын Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хуралдааны шийдвэрийг танилцуулж шийдвэр гаргуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2. Амралт, аялал жуулчлалын зохион байгуулах тухай түр журам, хуулийн этгээд болон иргэнтэй байгуулах хариуцлагын гэрээний төсөл танилцуулах,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

3. Өршөөл үзүүлэх хуулиар суллагдсан иргэдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах талаар хэлэлцэх,

4. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1. Матад, Булган, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Баян-Уул сумдын алслагдсан хяналтын цэгийн үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хэвийн үргэлжлүүлэх,

/ М.Бадамсүрэн

/ Хур Г.Нармандах

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр,
Ачаа тээврийн хяналтын багийн ахлагч нарт:

1.2.Улаанбаатар хот болон халдвар бүртгэгдсэн орон нутгаас ирсэн ачаа тээврийн хяналтын үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хэвийн үргэлжлүүлэх,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

1.3.Улсын Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хуралдааны шийдвэр, баяр наадмын амралтын өдрүүд эхэлж иргэдийн хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан Хөлөнбуйрын сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллах хүн, хүчийг нэмэгдүүлэх,

1.4.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт шинжилгээ авах цэг албан хаагчдыг нэмэгдүүлэх,

1.5.Шуурхай штабын бүрэлдэхүүнээс Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт хуваарийн дагуу томилж ажиллуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:



1.6.Улсын Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хуралдааны шийдвэр, баяр наадмын амралтын өдрүүд эхэлж иргэдийн хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 17:00 цагаас мөн оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд иргэд, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг хяналттайгаар нэвтрүүлэх,

1.7.Аялагчид нь аймгийн төв, сумын төвд хүнс, шатахуун, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, тээврийн хэрэгслээ засварлуулах тохиолдолд нэвтрэх бөгөөд бусад тохиолдолд нэвтэрсэн бол тухайн суурин газарт 7 хоног тусгаарлагдаж, 6 дахь хоног тандалтын шинжилгээнд хамрагдах,

1.8.Иргэд амралт, жуулчны бааз болон сумын төвд ирсэн тохиолдолд тухайн газраас өөр газарт зорчихгүй байхад хяналт тавьж ажиллах,

Аймгийн Засаг даргын туслах, Онцгой комиссын
гишүүн Х.Энх-Отгон-д:

1.9.Улсын Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хуралдааны шийдвэр, баяр наадмын амралтын өдрүүд эхэлж иргэдийн хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан иргэдээс хүсэлт хүлээн авах 70584647.mn цахим хуудсанд "Зөвхөн гэр бүлийн аялал" гэсэн шалтгааныг засварлаж оруулах,

 / М.Бадамсүрэн
 / Хур Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.10.Баяр наадмын амралтын өдрүүд эхэлж иргэдийн хөдөлгөөнийг нэмэгдэхтэй холбогдуулан эм, эмнэлгийн хэрэгсэл, түргэвчилсэн тестний нөөцийг бүрдүүлэх,

1.11.Хүүхэд, жирэмсэн эх, буяны ажил, эрүүл мэнд /13А,Б маягттай/, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс шинжилгээг төлбөр авахгүй байх,

1.12.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэл бүрээс 1 иргэнийг тандалтын шинжилгээнд хамруулах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.13.Сум хооронд зорчих хүсэлтэй 12-оос дээш насны вакцингүй иргэдээс түргэвчилсэн тестээр шинжилгээ авах, түргэвчилсэн шинжилгээний төлбөр 15,000 төгрөг байх,

1.14.Иргэд сум хооронд зорчсон тохиолдолд сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт шинжилгээг авах ажлыг зохион байгуулах,

1.15.Сум хооронд зорчих иргэд хүсэлт өгч бүртгүүлэн нэвтрэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

1.16.Нэг тээврийн хэрэгсэлд 5-аас илүүгүй зорчигч зорчуулах талаар хяналт тавьж ажиллах,



1.17.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог"-ын хяналтын цэгт ажиллах буй Хэнтий аймгийн албан хаагч нарт буусан тохиолдолд Дорнод аймгийн албан хаагч нарыг буулгах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

1.18.Дархлаажуулалтад хамрагдаагүй жирэмсэн эхчүүдийг алслагдмал хөдөө орон нутагт зорчихгүй байхыг зөвлөсөн тухай аймгийн Засаг даргын захирамж гаргах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

2.1.Баяр наадмын амралтын өдрүүд эхэлсэнтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн багийг Буйр нууранд томилж ажиллуулах,

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

2.2.Сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнтэй 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагт цахим хурлыг зохион байгуулж Улсын Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хуралдаан, аймгийн Онцгой комиссын 65 дугаар хуралдааны шийдвэрүүдийг танилцуулж үүрэг чиглэл өгч ажиллах,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,

2.3.Амралт, аялал жуулчлалын зохион байгуулах тухай түр журам, хуулийн этгээд болон иргэнтэй байгуулах хариуцлагын гэрээний төсөлд иргэдийн саналыг тусгаж батлуулах,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал,
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга,
дэд хурандаа Л.Эрдэнэбат,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Сум, багийн Засаг дарга нарт:

3.1."Өршөөл үзүүлэх тухай" хуулийн дагуу суллагдсан иргэдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Цагдаагийн газар ахлан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сум, багийн Засаг дарга нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, хяналт тавьж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Т.НАРМАНДАХ